



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 10

Өндөрхаан

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлыг 2018 оны 06 дугаар сарын сарын 29-ний өдрийн 15 цаг 00 минутад аймгийн Засаг даргын зөвлөлийн өрөөнд төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн Ч.Эрдэнэбаатар, Г.Болд, Г.Лхагвахатан Ж.Болд, Б.Сүнгээ, нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар удирдан эхлүүлэв.

Хэлэлцсэн асуудал:

1. МХГ-ын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн даргын сонгон шалгаруулалт явуулах тухай албан бичиг
2. С.Энхцэцэгийг нөөцийн сангаас нэр дэвшүүлэх

СОНССОН НЬ 1:

Дарга Ж.Ганбаатар: Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн даргын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж дүгнэлт гаргаж өгнө үү гэсэн албан бичгийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг сонгоно. Төрийн албаны зөвлөлтэй утсаар холбогдон лавлахад төсөв захирахгүй менежер тул Төрийн албаны салбар зөвлөлдөө журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуул гэсний дагуу ажлын хэсгийн ахлагчаар Б.Сүнгээ, нарийн бичгийн даргаар Ч.Болормаа, гишүүнээр Г.Болд нарыг томилж байна. Сонгон шалгаруулалтыг удирдах ажилтныг сонгон шалгаруулах журмын дагуу зохион байгуулж дүнг танилцуулна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн даргын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг томилов.

СОНССОН НЬ 2:

Ч.Болормаа: Төрийн албаны тухай хуулийн 27.2.4-өөр чөлөөлөгдөн төрийн албан хаагчийн нөөцөд орсон С.Энхцэцэгийн Орон нутгийн өмчийн газрын өмчийн бодлого

зохицуулалтын мэргэжилтний орон тоон дээр нэрийг дэвшүүлж өгнө үү гэсний дагуу С.Энхцэцэгийн материал, Орон нутгийн өмчийн газрын өмчийн бодлого зохицуулалтын мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт зэргийг хянан үзээд Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журмын 6.3-ыг баримтлан томилон ажиллуулж болох юм байна гэж үзэж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ.

Гишүүдийн 100 хувийн саналаар С.Энхцэцэгийг Орон нутгийн өмчийн газрын өмчийн бодлого зохицуулалтын мэргэжилтний ажлын байранд нөөцөөс нэр дэвшүүлэх тогтоолыг гарган албан бичгээр хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хурал: 16:30 минутад дуусав.

ХУРАЛ УДИРДСАН:

Ж.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХӨТӨЛСӨН:



Ч.БОЛОРМАА